

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Сономдагвын Төгс	Дугаар	L323
Оршин суугаа аймаг	Өвөрхангай	Оршин суугаа сум	Уянга сум
Төрсөн газар	Уянга сум	Төрсөн он	1942
Ажил мэргэжил	Ловон лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Сайн ноёны хүрээ	Сүм хийдийн дугаар	ӨХУЯ 027
Одоогийн сүм хийд	Уянгын шинэ хийд буюу Ганданцэмбэллин хийд	Сүм хийдийн дугаар	ӨХУЯ 028
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 2	Ярилцлага авсан хүн	Жужа



Өвөрхангай аймгийн Уянга сумын Шинэ хийд болон Сайн ноёны хүрээ

Жужа: Танай хийд хэзээ байгуулагдсан бэ?

Ловон лам: Манай хийд 1990 онд анх дахин сэргээгдэж байгуулагдсан.

Жужа: Хэний санаачилгаар байгуулагдсан бэ?

Ловон лам: Анхны 7 хүний санаачилгаар, Цэдэнжанчив, Өлзийбадрах, Бат-Уул, Гомбо гэдэг 4 багш, лам Дашцэвэг гэж хүн байсан. Миний бие Төгс, тэгээд Сийлэгмаа ийм 7 хүний санаачилгаар үүсгэн байгуулагдсан. Манай хийд чинь уг нь 300 гаруй жилийн түүхтэй том хүрээ байсан.

Жужа: Энэ хаана хаана хүрээд сууж байсан лам нар байна?

Төгс: Хийдэд сууж байсан ганцхан өвгөн тэр Дашцэвэг гэж өвгөн байсан. би ерэн оноос хойш сууж байна.

Жужа: Одоо хэдэн ламтай вэ?

Төгс: Жинхэнэ цуглахаараа бол 42 ламтай байдаг. Майнх чинь санхүү муутай болохоор өөрсдөө бас амьдралаа хөөгөөд л , яахав бүтээл, цагийн хурлаар хааяа хурдаг. Байнгын хурж байгаа нь 20 гаруй лам нар байдаг.

Жужа: Цогчин өдөр болгон хурах уу?

Төгс: Өдөр болгон хурна.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Гол шүтээн сахиус?

Төгс: Лхам, Гомбо.

Жужа: Сарын дүйчэн өдрүүдээр ямар ямар хурал хурах вэ?

Төгс: Манайх ард түмний хүссэн хурлуудыг л хурна. Бас тэгээд дүйчэн өдрүүдээр бол дарь эхийн мандал шива, бурхан багшийн юуг хурж, ганжуур хурна, говийн лха, хорин есөнд хангал хурна.

Жужа: Шинийн найманд?

Төгс: Их манал хурна. 15-нд ганжуур, есөн эрдэнийн доржзод хурна.

Жужа: Тэр гэрэлт хөшөө ямар хөшөө вэ?

Төгс: Тэр гэрэлт хөшөө бол сайн ноён хан Намнансүрэн гэж анхны ерөнхийлөгч байсан.

Жужа: Тэр энэ нутгийн хүн үү?

Төгс: Тийм, энэ тэр сайн ноён ханы өөрийнх нь жасаа хурал байсан. Нанслан гэдэг дуганы суурин дээр баригдсан.

Жужа: Хөшөө хэзээ босгосон бэ?

Төгс: Хөшөө 1997 онд босгосон байх аа.

Жужа: Суваргуудыг?

Төгс: Суваргуудыг 1993 онд нэгийг босгоод л, 1994 онд, 1997 онд, 2000 онд сүүлийнхийг нь босголоо доо.

Жужа: Тэр ямар ямар учиртай суваргууд вэ?

Төгс: Манай анхны хамба тэр Балдандорж гэдэг хүний зориулалттай, хуучин манай гандан хүрээний том эрдэмтэн Юндэнбат гэж гэвш байсан. Байгуулахад бас 2 Дашцэвэг гэдэг лам их оролцоотой ажиллаж байсан. Тэгээд хүрээ устсанаас хойш хуваргынхаа дээлийг тайлаагүй ганц лам байсан. Тэр 3 ламыг хамтатгаж нэг суварга босгосон байгаа юм.

Жужа: Хийдийн дотор байгаа 2 багана хуучин уу, шинэ үү?

Төгс: Шинэ.

Жужа: Хоёр хүрд байна тийм ээ?

Төгс: Тийм, энэ ноднин 2 бурхан болоочийн үр хүүхдүүд нь бүтээсэн. Нэг нь тэр Сэрчим гэж нэг хүн байсан юм. Цаадах нь бол тэр Пүрэвжамбаа гэдэг хүний дурсгалд зориулж бүтээсэн.

Жужа: Танайх өөр хийдүүдтэй холбоотой ажиллаж байна үү?

Төгс: Бид нар бол нэг их холбоотой ажилладаггүй. Яахав нааш, цаашаа явж ирдэг. Тэгээд сурахаар явсан хүүхдүүд нь тэндээ шингээд алга болчихдог. Бие биенээсээ бас асууж сурах юм байлгүй яахав.

Жужа: Хуучин Сайн ноён хан аймгийн аль дуган энд байсан бэ?

Төгс: Энэ Нанслын дуган гэж байсан. Ноёны өөрийнх нь хариуцаж байсан дуган.

Хамгийн жижиг дуган байсан.

Жужа: Хамгийн сүүлийн хамба нь ямар хүн байсан бэ?

Төгс: Намнансүрэнгийн хүү Батсүх гэж хүн байсан. тэр нь их нас жоохон тэгээд хэлмэгдээд л явсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Хуучин хүрээнд хэдэн хүн амьдардаг байсан бэ?

Төгс: 3000-аад хүн байсан гэж байгаа юм. Арван хэдэн дацантай, цол хэргэм мяндаг тушаал яадаг одоо ухааны сургууль гэх үү дээ. Аранжингийн мяндаг өгдөг тийм дээд цол өгдөг байсан байгаа юм.

Жужа: Хуучин хүрээнд сууж байсан өвгөн лам одоо байна уу?

Төгс: Анх 40 лам хүрж байсан гэж байгаа юм. Одоо 3 өвгөн лам байгаа, ер гарчихсан.. Харин өчигдөр нэг лам нь ирээд энэ хөгшин ламын дурсгалд зориулаад суварга бүтээж өгөөч гэж надаас хүсэлт тавьсан. Би тэгээд хот орж Пүрэвбат ламтай уулзаж бас заавар зөвлөгөө авдаг юм уу гээд л. Жамъянсанги гэж өвгөн байдаг юм. Хойно нэг Цэрэндорж гээд өвгөн байгаа. Нарийн тээлд Дашдорж гээд нэг өвгөн ингээд 3. Ерөөсөө Сайн ноёны хошуу хүрээ эхлээд байгуулахад 40 лам байсан гэж байгаа юм. Тэгээд хойно тэр шүтээний бурхан энэ тэрийн музейрхүү юм болсон байгаа юм. Тэгээд устаад хэн ч тоогоогүй. Хурал хураад дахиад сэргэсэн чинь бас 40 лам болдог юм. Энэ их сонин түүх л дээ. Манайд бол 30 гаран дуган байсан гэж байгаа юм. Бүтэн ганц тоосго үлдээгүй. Гучин долоон оноос хойш устгаад л, лам нарыг бариад л. Голцуу л Орос руу ч зөөсөн.

Жужа: Хүрээний хутагт хувилгаан лам нар байсан уу?

Төгс: Алдартай хутагт багш Довчинсодном гэж байсан байгаа юм. Тэр Юндэнбат гэж том лам байсан байна. Манайх чинь Төвдөөс Гачин лам гээд залдаг. Хамгийн сүүлийн Гачин багш гэж зураг байдаг юм. Манайх чинь тэр Гачин залж байсан түүхтэй.

Жужа: Хуучин зургууд байгаа юу?

Төгс: 1923 оны зураг байгаа. Манай их хурлын гишүүн тодруулж сэргээж өгсөн. Нэг жижигхэн байдаг гэсэн, тэр хаана явдаг юм. Манайд лав байдаггүй.

Жужа: Хуучин сүм хийдээс үлдсэн бурхан шүтээн байгаа юу?

Төгс: Хуучин сүм хийдээс үлдсэн бурхан шүтээн байхгүй. Ном судар бол байгаа, айлуудын өгсөн.

Жужа: Тэгээд энэ өө шинэ сүм хийд байгаа юу, энд?

Төгс: Байхгүй. Энчээ манай энэ нэг лам сүм босгох гээд л. Би одоо бас энэнд хань болох гэж их зовж байсан. Мөнгө олдохгүй бас хэцүү л дээ. Сэлэнгэ энэ тэр явж хүртэл мөнгө хандив цуглуулж байсан.